



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**

Гүйцэтгэлийн аудитын тайлан

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР
ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ 93.0
ХУВЬ НЬ ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРСЭН БАЙНА**

**2024 оны 04
дүгээр сар**

**АУДИТЫН СЭДЭВ: УЛСЫН ТӨСВИЙН 2023 ОНЫ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас: 70422954 Цахим хаяг: Aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Айнур

Утас: 94159291 Цахим хаяг: ainurm@audit.gov.mn

Аудитор: С.Нурлан

Утас: 99103281 Цахим хаяг: nurlans@audit.gov.mn

2024 он

АГУУЛГА

АГУУЛГА	2
Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	4
Хавсралтын товъёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
А. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 2023 онд санхүүжүүлэх дүнгийн 56 хувийг гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.	7
А.2. Тайлант онд 26 төсөл арга хэмжээний санхүүжилтэд 22,584.8 сая төгрөгийг олгосон байна	7
А.3. Төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон байна	9
Б.Төлөвлөсөн арга хэмжээний 93.0 хувийг хугацаанд нь гүйцэтгүүлсэн байна.	11
Б.1. Тайлант онд хэрэгжүүлэх нэг төсөл арга хэмжээ нь гэрээт хугацаанд хэрэгжээгүй байна	11
Б.2. Төсөл, арга хэмжээнд тавих бүх шатны хяналтыг хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авсан байна.	12
Б.3. Ашиглалтад хүлээн авсан 11 төсөл, арга хэмжээний 10 төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллага бүртгэлд тусгажээ.	14
В. Тайлант онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний 93 хувь нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна	15
В.1. Тайлант онд ашиглалтад орсон 14 төсөл арга хэмжээнээс 1 төсөл ара хэмжээг зориулалтын дагуу ашиглахгүй байна.	15
В.2. Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний 92.9 хувь нь иргэдийн хэрэгцээ шаардалгыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна	19
ДҮГНЭЛТ:	23
ЗӨВЛӨМЖ:	24
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	<i>Error! Bookmark not defined.</i>

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дэд байгууллагын олон улсын стандарт
БХБС	Барилга хот байгуулалтын сайд
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
СС	Соёлын сайд
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЗТХС	Зам тээврийн хөгжлийн сайд
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ХНХС	Хөдөлмөр, нийгмийг хамгаалах сайд
ХХААХҮС	Хүнс хөдөө аж ахуй хөнгө үйлдвэрийн сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЕЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөө бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ҮАГ	Үндэсний аудитын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

Хүснэгтийн товъёг

Хүснэгт 1	Төсөл арга хэмжээний өртөг, гэрээний дүнгийн мэдээлэл	8
Хүснэгт 2	Төсөл арга, хэмжээний хүчин чадал, гэрээний дүн	9
Хүснэгт 3	Санхүүжилтийн мэдээлэл, ажлын гүйцэтгэл	10
Хүснэгт 4	Барьцаа дансны мэдээлэл	11

Хавсралтын товъёг

Хавсралт 1	Улсын комисс нь тайлант онд болон 2021-2022 онуудад байнгын ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээний жагсаалт	23
Хавсралт 2	Төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авсан байдал	24
Хавсралт 3	Захиалагч, мэргэжлийн байгууллагын, Зураг төсөл зохиогчийн хяналт	25-26
Хавсралт 4	Төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авч, нягтлан бодох бүртгэлд тусгасан төсөл, арга хэмжээний жагсаалт	

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/162 дугаар тушаал, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг Улсын Их хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх,
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх,
- Хэрэгжсэн төсөл арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх,

Аудитын хамарсан хүрээ

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж Баян-Өлгий аймагт хэрэгжсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг Төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагууд Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, барилга захиалагчийн алба, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын хэлтэс зэрэг холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын хязгаарлалт

Байхгүй

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

зүйг ашиглав./Асуудлын шинжилгээг хавсралт №2, аудитын загарын матрицыг хавсралт №3-т үзүүлэв/

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор М.Айнур, аудитор С.Нурлан нар хамтран гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 3 сарын 18-наас 4 сарын 10-ны дотор гүйцэтгэсэн ба тайлагналын үе шатны ажлыг 2024 оны 4 сарын 08-наас эхлүүлж, 4 сарын 18-ны хооронд хийж, 4 сарын 19-ны дотор Үндэсний аудитын газарт, 4 сарын 23-ны дотор холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

Хүндрэл бэрхшээл

Аудитын талбарын ажлыг санхүүгийн тайлангийн аудитын дараа богино хугацаанд төлөвлөж хэрэгжүүлсэн тул ачаалалтай ажилласан, хугацааны хувьд богино байв.

А.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон байна

А.2. Нэг төсөл арга хэмжээнээс бусад арга хэмжээний санхүүжих дүнг бүрэн тооцож тусгасан байна

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар Баян-Өлгий аймагт шинээр хэрэгжих төсөл арга хэмжээ тусгагдаагүй байна.

Төсвийн тухай хуулиар 2022-2023 онд эрх шилжиж хэрэгжихээр тусгасан 34 төсөл арга хэмжээ нь шилжих хөрөнгө оруулалт бөгөөд анхны төсөвт өртөг нь 83,039.2 сая төгрөг, 2023 оны төсвийн хуулиар төсөвт өртөг нь 97,304.1 сая төгрөг, 2023 онд санхүүжүүлэх дүн нь 40,326.1 сая төгрөг байна.

Он дамжин хэрэгжиж буй 34 төсөл арга хэмжээний анхны төсөвлөгдсөн өртөг 14,264.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

2023 оны төсвийн тухай хуульд тусгагдаагүй боловч онд дамжин хэрэгжиж буй

- Үерийн усны хамгаалалтын далан сувгийн эхний ээлжийн ажил /Баян-Өлгий, Өлгий сум, 4, 11-р баг/,
- 1000, 900 айлын орон сууцны хороолол, ус дамжуулах төвийн гадна инженерийн шугам сүлжээний ажил /Баян-Өлгий, Өлгий/ төсөл арга хэмжээ нь нэмэлт гэрээ байгуулан БХБЯ-ны сайдын багцаас барилгын материалын үнийн өсөлтийг санхүүжүүлэхээр гэрээ байгуулсан байна.

Үерийн усны хамгаалалтын далан сувгийн эхний ээлжийн ажлын гэрээний дүн 4,990.0 сая төгрөгийг барилгын материалын үнийн өсөлтийн 552.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, гэрээний нийт дүнг 5,542.6 сая төгрөг байхаар, 1000, 900 айлын орон сууцны хороолол, ус дамжуулах төвийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын гэрээний дүн 2,988.0 мянган төгрөгийг барилгын материалын үнийн өсөлтийн 241.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, гэрээний нийт дүнг 3,229.8 сая төгрөг байхаар 2023 оны 06 сарын 06-ны өдөр нэмэлт гэрээ байгуулсан байна.

Тайлант онд хэрэгжсэн 36 төсөл арга хэмжээний өртөг, санхүүжих дүнг хүснэгтээр харуулав.

Хүснэгт №01

/ сая төгрөгөөр/

ТЕЗ-ийн нэр	ТАХ-ний тоо	анх төлөвлөсөн дүн	2023 оны төсвийн тухай хуульд тусгасан төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн	Гэрээний дүн		төсөвт өртөг нэмэгдсэн дүн	төсөв нэмэгдсэн ТАХ-ын тоо
					анхны	сүүлийн		
ЗГХЭГ	1	7501.4	9,236.2	1,734.8	7,501.4	9,236.2	1,734.8	1
ХНХЯ	1	1,910.0	6,803.9	500.0	1,910.0	6,803.9	4,893.9	1
ХХААХҮС	1	1,913.2	1,998.3	91.9	1,906.4	1,998.3	91.9	1
БШУС	19	42173.8	47,783.9	23,174.5	40,056.4	62,325.9	22,269.5	15
БХБС	3	8263.7	380.5	85.4	8263.7	9,143.5	879.8	3
ЗТХС	7	20426.9	20,434.9	11,552.7	20,304.0	20,433.9	129.9	1
Соёлын Яам	1	1,683.2	2,763.1	300.0	1,676.8	2,763.1	1,086.3	1
ЭМЯ	1	245.0	1,003.3	50.0	245.0	1,003.3	758.3	1

ЭХЯ	2	6,900.0	6,900.0	2,836.7	6,900.0	6,900.0	0.0	0
Нийт	36	91,017.20	97,304.14	40,326.00	88,763.74	120,608.09	31,844.35	24

Эх сурвалж: Аудитын нэгдсэн судалгааны маягт

Тус аймагт 2023 онд хэрэгжүүлэхээр тусгасан төсөл арга хэмжээний нийт өртгийн 41.4 хувийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

9 яамны сайдын багцын хөрөнгөөр санхүүжихээр төлөвлөгдсөн 36 төсөл арга хэмжээнээс 24 төсөл арга хэмжээний гэрээний дүн анхны гэрээний дүнгээс 31,844.3 сая төгрөгөөр нэмэгдэж, үнийн нэмэгдлийг олгосон гэрээ хийсэн байна.

Гүйцэтгэлээр 26 төсөл арга хэмжээний 19 хувийн гүйцэтгэлийн санхүүжилтэд 22,584.8 сая төгрөгийг олгосон байна.

2021-2022 оны шилжих хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 2 төсөл арга хэмжээ буюу Багийн эрүүл мэндийн төвийн барилга, 5 ор /Баян-Өлгий, Ногооннуур сум, Улаанхад баг/, Шилэн кабельд холбох, зураг төсөв боловсруулах /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөххөтөл баг/5 дугаар багц төсөл арга хэмжээнд 2023 оны төсвийн тухай хуулиар хөрөнгө хуваарилагдаагүй байна.

Шилэн кабельд холбох, зураг төсөв 5 дугаар багцын төсөл арга хэмжээ хэрэгжиж эхлээгүй байна.

Төсөвт өртөг нь нэмэгдсэн төсөл арга хэмжээнүүдээс 320 суудалтай сургуулийн барилга /Баян-Өлгий, Цэнгэл сум/-ын анхны гэрээний дүн нь 7,401.7 сая төгрөг бөгөөд нэмэлт гэрээгээр төсөвт өртгийг 40.2 хувиар буюу 4,965.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт гэрээг 12,367.0 мянган төгрөгөөр хийсэн нь анхаарал татаж байна.

Сургуулийн төсөвт өртөг, гэрээний дүнг аймгийн төв болон Цэнгэл сумд баригдаж байгаа зарим сургуультай харьцуулж үзэхэд үлэмж хэмжээний төсөв хуваарилагдсан бөгөөд харьцуулсан судалгаа дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №02

ТАХ-ын нэр	эрх шилжсэн /тийм, үгүй/	хүчин чадал	сүүлийн гэрээний дүн	нэмэлт гэрээгээр нэмэгдсэн дүн
Сургуулийн барилга, 320 суудал /Баян-Өлгий, Цэнгэл сум/	тийм	320	12,367.0	4,965.3
Бага сургуулийн барилга, 360 суудал /Баян-Өлгий, Цэнгэл сум, Тува бага сургууль/	үгүй	360	2,722.10	0
Сургуулийн барилга, 640 суудал /Баян-Өлгий, Өлгий сум, Кутты мекен хотхон/	үгүй	640	5,708.50	0

Эх сурвалж: Аудитын судалгааны маягт

Эрх шилжээгүй хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй аймгийн төвийн Сургуулийн барилга, 640 суудалтай /Баян-Өлгий, Өлгий сум, Кутты мекен хотхон/ төсөл арга хэмжээний гэрээний дүн 5,708.5 сая төгрөг, 360 суудалтай Цэнгэл сумд баригдаж байгаа бага сургуулийн барилга, /Баян-Өлгий, Цэнгэл сум, Тува бага сургууль/ төсөл арга хэмжээний гэрээний дүн 2,722.1 сая төгрөг байгаа нь харилцан адилгүй байна.

Иймд Цэнгэл сумын 320 суудалтай сургуулийн барилгын төсөвт өртгийг 12,367.0 сая төгрөгөөр тогтоосныг хянан үзэх шаардлагатай байна.

А.3. Төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон байна

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд эрх шилжсэн 97,307.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 төсөл арга хэмжээний гэрээний дүн 120,608.1 сая төгрөг байна.

Дээрх төсөл арга хэмжээнүүдэд ажил эхэлснээс хойш олгосон санхүүжилт нь 74,207.8 сая төгрөг, 2023 оны 1 дүгээр сараас 10 сар хүртэлх аймгийн эрх шилжсэн яамдын данснаас 22,584.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Санхүүжилт олгосон байдлыг төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр харуулбал.

Хүснэгт №03					/сая төгрөгөөр/	
ТЕЗ-ийн нэр	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Ажил эхэлснээс хойших санхүүжилт	2023 оны 1-10 сар хүртэл хугацаанд гүйцэтгэгчид олгосон санхүүжилт	Хувь
ЗГХЭГ	1	9,236.2	9,236.2	9,215.8	1,734.8	99.8
ХНХЯ	1	6,803.9	6,803.9	2,410.0	277.5	35.4
ХХААХҮС	1	1,998.3	1,998.3	1,906.4	0.0	95.4
БШУС	19	47,783.9	62,325.9	29,460.5	11,594.4	58.1
БХБС	3	380.5	9,143.5	8,181.0	85.4	92.8
ЗТХС	7	20,434.9	20,433.9	19,126.7	7,195.8	93.8
Соёлын Яам	1	2,763.1	2,763.1	1,976.8	297.4	71.5
ЭМЯ	1	1,003.3	1,003.3	171.0	0.0	17.1
ЭХЯ	2	6,900.0	6,900.0	1,759.6	1,399.6	27.7
Нийт	36	97,304.14	120,608.09	74,207.80	22,584.90	

Эх сурвалж: Аудитын нэгдсэн судалгааны маягт

Аймгийн Засаг дарга нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гэрээ, гүйцэтгэл, тайлан, гэрээ дүгнэх акт, хяналтын баримт бичгийн гарын үсэг зурах эрх олгох тухай 3 удаа захирамж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гэрээ, гүйцэтгэл, тайлан, гэрээ дүгнэх акт, хяналтын баримт бичигт гарын үсэг зурах эрх олгох тухай 1 удаа захирамж гаргасан байна.

Дээрх захирамжийн хүрээнд гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтнуудын хооронд үүссэн зөрчилтэй асуудлаас үүдэн Сангийн сайдын 2023 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн СХШХ/06 тоот удирдамжийн дагуу хяналт, шалгалт хийж, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулсан байна.

Шалгалтын үр дүн, Засгийн газрын хэрэг эрхлэх газраас ирүүлсэн албан бичгийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.3, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар батлагдаж, Баян-Өлгий аймагт эрх шилжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, санхүүжилтийг хянан баталгаажуулах үйл ажиллагааг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчдад буцаан шилжүүлсэн байна.

Иймд дээрх судалгаанд зөвхөн Баян-Өлгий аймгийн эрх шилжсэн яамдын санхүүжилтийн данснаас олгосон санхүүжилтийн дүнг тусгалаа. /Судалгааны нэгтгэл маягтын тайлбар хэсэгт 10 сараас хойш яамдаас олгосон санхүүжилтийн дүнг тусгасан/

Барьцаа хөрөнгийн дансанд 2021-2022 оны эцэст байршуулсан санхүүжилтээс 2023 онд Улаанхус сумын Хөххөтөл багийн шилэн кабельд холбох ажил 5 дугаар багц төсөл арга хэмжээний 165.9 сая төгрөгийг, Цэцэрлэгийн барилга 50 ор, Ногооннуур сум, Улаанбайшинт төсөл арга хэмжээний 257.4 сая төгрөгийг, Хот тохижилтын парк шинэчлэл төсөл арга хэмжээний 0.04 сая төгрөгийг, нийт 423.3 сая төгрөгийг төв төрийн санд буцаан төвлөрүүлсэн байна.

Барьцаа хөрөнгийн дансанд 2022 оны жилийн эцсээр байршуулсан 222.9 сая төгрөгийн санхүүжилтээс 13 төсөл арга хэмжээний 82.7 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч компани, зураг төсөв зохиогчийн болон хяналтын зардалд олгосон байна.

2023 оны жилийн эцсээр 3 яамны сайдын 4 төсөл арга хэмжээний 131.0 сая төгрөгийн санхүүжилтийг барьцаа санд байршуулсан байна.Үүнд:

Хүснэгт №4		/мянган төгрөгөөр/	
д/д	Сайдын багц	төсөл арга хэмжээний тоо	төвлөрүүлсэн санхүүжилт
2	БШУС	2	124,789.1
3	Соёлын сайд	1	2,650.6
4	ЗТХС	1	3,572.4
Нийт дүн		4	131,012.1

Эх сурвалж: Барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн санхүүжилт

Аудитаар Сангийн яамнаас 2023 оны 7 сараас хойш Баян-Өлгий аймагт эрх шилжин хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, санхүүжилтийг хянан баталгаажуулах үйл ажиллагааг холбогдох ТЕЗ-д буцаан шилжүүлсэнтэй холбоотой гүйцэтгэгч компаниудын санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын гүйцэтгэлийг зөвхөн аймгаас олгосон санхүүжилтийн гүйцэтгэлийн дүнгээр тайлагнасан.

Иймд зарим гүйцэтгэгч компаниуд холбогдох яамдын багцаас санхүүжилтийн гүйцэтгэл авсан байх тул судалгаанд байгаа ажлын гүйцэтгэл, бодит ажлын гүйцэтгэл нь зөрүүтэй гарахаар байна.

Аудитын явцад гүйцэтгэгч компани тус бүртэй уулзалт хийж, санхүүжилт, ажлын гүйцэтгэлийн талаар мэдээлэл цуглуулж, аймгаас олгосон гүйцэтгэлийг тулган баталгаажуулж, яамдын багцаас олгосон санхүүжилтийн талаар мэдээллийг судалгааны тайлбар хэсэгт тусгасан болно.

Эрх шилжсэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн эрхийг яамдын ТЕЗ-дад буцаан татсантай холбоотой санхүүжилтийн гүйцэтгэлийг хянуулах, баталгаажуулах, санхүүжилт авах процесс нь хүндрэл учруулж байгаа талаар гүйцэтгэгч компаниудаас санал гомдол гаргаж байна.

Б.Төлөвлөсөн арга хэмжээний 93.0 хувийг хугацаанд нь гүйцэтгүүлсэн байна

Б.1. Нэг төсөл арга хэмжээ тодорхой шалтгааны улмаас гэрээний хугацаанд хэрэгжээгүй байна

Тайлант онд төлөвлөсөн 36 төсөл арга хэмжээний 14 төсөл арга хэмжээ нь бүрэн хэрэгжиж, 22 төсөл арга хэмжээний хэрэгжилт 4.8 -87.9 хувьтай байна.

Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг захиалагчийг төлөөлж аймгийн Засаг даргатай хийсэн гэрээний дагуу Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Барилга захиалагчийн алба хэрэгжүүлсэн байна. Зохиогчийн хяналтыг зураг төсөл боловсруулсан аж ахуйн нэгжүүд хэрэгжүүлжээ.

Аудитаар 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 36 төсөл арга хэмжээг хугацаандаа бүрэн хэрэгжүүлсэн эсэхийг шалгаж үзэхэд хэрэгжиж дуусах 15 төсөл арга хэмжээний 14 нь бүрэн хэрэгжиж, 1 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна. Энэ нь Ногооннуур сумын 6 дугаар багт баригдаж байгаа 160 суудалтай Бага сургуулийн барилга тодорхой шалтгааны улмаас хугацаандаа хэрэгжээгүй байна.

Бага сургуулийн барилгын ажлын гүйцэтгэгч “Мурап” ХХК-наас шалтгааныг тодруулахад:

Бага сургуулийн барилгын төсөвт өртгийг тэргүүлэх төсөвчний 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн эксперт №9-14 дугаар магадлалын дүгнэлтийн хавсралтаар 3,157.4 сая төгрөгөөр хянасан байна. Харин Барилгын хөгжлийн төвийн 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 2263/2022 тоот магадлалын ерөнхий дүгнэлтээр тухайн ажлын улсын төсөвт батлагдсан дүнд тааруулж 2,403.3 сая төгрөг болгон 1 м.кв-ын норм нормативд заасан үнийг бууруулж баталжээ.

Барилгын хөгжлийн төвийн магадлалаар баталсан төсөвт өртөгт ажиллах хүч, материалын зардлаас 150.7 сая төгрөг, барилгын гол түүхий эд болох цемент, тоосго, хөнгөн блок, хөөсөнцөр, гадна эмульс зэрэг материалын хоорондын зай бага тооцогдсоноос тээврийн зардлаас 202.0 сая төгрөг, компанийн төсөвт ашгаас 5% буюу 250.4 сая төгрөгийг бууруулж тооцжээ.

Энэхүү төсөвт өртгөөр тус барилгын ажлыг графикт хугацаанд барьж ашиглалтад оруулах боломжгүй байгаа тул экспертээр орсон төсөв, Барилгын хөгжлийн төвөөс баталсан төсвийн зөрүүг хууль журмын дагуу хянах шаардлагатай болсон байна.

Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын баг 2024 оны 4 дүгээр сарын 17, 18, 19-ний өдрүүдэд тус аймагт 2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээний хэрэгжилтийг газар дээр нь үзэж шалгахад дараах алдаа зөрчлүүд илэрсэн байна.Үүнд:

Цэцэрлэгийн барилга, 250 ор /Баян-Өлгий, Өлгий сум/

- Тус цэцэрлэгийн гадна талд хүүхдийн тоглоомын талбайн хэсгийг цементлээгүй, хүүхдийн унаж бэртэхээс хамгаалсан зөөлөвч хийгээгүй,

Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум, 5 дугаар баг/

- Цэцэрлэгийн хойд хэсэгт байрлах нам даралтын зуух ажиллагаатай байх үед цахилгаан тасарч шахагч насос нь ажиллахгүй болоход зуух дэлбэрэх аюултай.Иймд нэмэлтээр нөөц генератор байрлуулах шаардлагатай,

- Интернет нь физ кабель байхгүй бөгөөд хананд байгаа интернет холболтод холбоход интернет ордоггүй,
- Цэцэрлэгийн гадна тохижилт гадна талбай цементлэх буюу ногоон байгууламж хийгдээгүй,
- Барилгын зураг, гүйцэтгэсэн ТАХ-тэй холбоотой баримт, материалыг ашиглагч байгууллагад хүлээлгэж өгөөгүй,
- Шитийн өрөөний хаалга анхааруулах тэмдэг байхгүй, төмөр хаалга хийж цоожтой байх ёстой боловч модон хаалга байрлуулсан,
- Уурын зуух нам даралт ажиллах өрөөнд агааржуулалтын хоолой гаргаагүй,

Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум, 4 дүгээр баг, 20 дугаар цэцэрлэг/

- Цэцэрлэгийн барилгын ашиглалтад хүлээн авсан боловч үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гараагүй байна.
- Интернет холбогдоогүй (физик кабель тавьсан, интернет тавигдаагүй),
- Цэцэрлэгийн доор цэвдэгтэй тул үүдний хэсэг шат болон суурь хэсэг хагарч товойсон,
- Нам даралтын зуух буюу уурын зуух нэмэлт насос байхгүй тул цахилгаан тасрахад дэлбэрэлт гарах аюултай.
- Цахилгааны шитийн хаалга төмөр хаалгаар хийгдээгүй, анхааруулах тэмдэг тавиагүй,
- Барилгын зураг, гүйцэтгэсэн ТАХ-тэй холбоотой баримт, материалыг ашиглагч байгууллагад хүлээлгэж өгөөгүй,
- Цэцэрлэгийн гадна тохижилт хийгдээгүй,

Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга /Баян-Өлгий, Өлгий сум/

- Барилгын дотоод өрөө тусгаарлах ханын өргөнийг 12-ын хэмжээтэй, өндөр нь 3м гаруй хийсэн нь нурах магадлалтай,
- Дотор ханыг тоосгоор өрөх явцад бэхэлгээ төмрийг стандартын дагуу хийгдээгүй буюу 8 үе, 16 үе өрөөд бэхэлгээ төмөр хийсэн зөрчилтэй,
- Аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүй (1 давхраас 2 давхарт гарах шатанд ажиллаж байгаа хүн унахаас сэргийлсэн тууз болон бэхэлгээг хийгээгүй байна),
- 1 давхарт агааржуулалтын хоолойг хэт доогуур тавьсан, агааржуулалтын хоолойноос шал хүртэлх хэмжээ алдагдсан байх магадлалтай.

Иймд гүйцэтгэгч компани болон ашиглагч байгууллагын зүгээс гарсан зөрчлийг арилгаж ажиллахыг аймгийн Засаг дарга, ХБТХОХ-т зөвлөмж болголоо.

Б.2. Төсөл, арга хэмжээнд холбогдох хяналтыг хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авсан байна

Тайлант онд хэрэгжиж дуусах 45,641.6 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээнээс, 42,362.2 сая төгрөгийн 12 төсөл, арга хэмжээнүүдийн ажлын явцад бүх шатны хяналтыг хэрэгжүүлж ашиглалтад хүлээн авсан бөгөөд 3,279.4 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг 2021-2022 онд тус тус хүлээн авсан байна. /Хавсралт № 1/

Улсын комиссын байнгын ашиглалтад оруулсан ТАХ-ний гэрээний хугацааг шалгаж үзэхэд хэрэгжиж дууссан 11 төсөл, арга хэмжээний 10 төсөл, арга хэмжээ нь хугацаанаас 26-233 хоногийн өмнө, 1 төсөл, арга хэмжээ нь 1 хоногоор хоцорсон байна.

Тус комисс нь төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авахдаа “барилга байгууламжийн төсөл арга хэмжээнд өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн хуудас”-ыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 4 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу хөтөлж, үүрэг даалгаврын биелэлтийг тооцож, үүрэг даалгаврын биелэлтийг үндэслэн ашиглалтад хүлээн авах актыг үйлдсэн байна.

Аймгийн Засаг дарга нь 2022-2023 онд эрх шилжин хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд захиалагчийн хяналтын чиг үүргийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Барилга захиалагчийн албатай тус тус гэрээ байгуулан хэрэгжүүлсэн байна.

Улсын төсвийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн, зохиогчийн хяналт болон мэргэжлийн байгууллага дараах хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар 25 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг, Барилга, захиалагчийн алба 8 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд техникийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Хяналтын байгууллагууд барилга байгууламжийн үе шат болгонд хэрэгжүүлэх техникийн хяналтыг графикт хугацаанд нь тавьж, илэрсэн зөрчлийг барилга байгууламжийн талбайн хяналтын дэвтэрт тухай бүрд тэмдэглэж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан байна. /хавсралт №2,3/

Тайлант онд хэрэгжсэн 36 төсөл, арга хэмжээнд 19 компани /хуулийн этгээд/ зураг төсөл, зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- “АЕСН” ХХК 10, “Эм Си Пи Си Жи Ар” ХХК 3, “Кадсүрвэй” ХХК 3, “Жаргалант хийц” ХХК, “Бодит чадал” ХХК, “Максимумлайн” ХХК, “Зэдпрожект” ХХК тус бүр 2, “Скайлайн дизайн” ХХК, “Рус-Нур” ХХК, “Кингсий инженер энд констракшн консалтинг групп” ХХК, “ТГТ” ХХК, “Тод прогресс” ХХК, “Аркон” ХХК, “Монхидроконстракшн” ХХК, “ДНТ” ХХК, “Ихэр Мөнх” ХХК, “Энх төсөл, арга хэмжээнд “Криетив Монголия” ХХК тус бүр 1 арга хэмжээнд зураг төсөв, зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Зам тээвэр, хөгжлийн яамны багцын хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл арга хэмжээний хэрэгжилтэд зам гүүрний улсын ахлах байцаагч 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд хяналтыг хэрэгжүүлжээ. Үүнд:

- Алтай сумын төвийн хатуу хучилттай авто зам, Алтанцөгц сумын төвийн хатуу хучилттай авто зам, Толбо сумын төвийн 2.3 км хатуу хучилттай авто зам, явган хүний зам, гэрэлтүүлэг, шугам сүлжээний хамгаалалт, өөрчлөлтийн ажил, Уурхай, Сагсай сумын 1.6 км чиглэлийн авто зам, гэрэлтүүлэг, шугам сүлжээ, Улаанхус сумын Хөх хөтөл багийн бетон гүүр, Бугат сумын Тоорцог толгойн төмөр бетон гүүр зэрэг 6 төсөл, арга хэмжээ хамрагдаж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулсан байна.

Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс эрх шилжсэн хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлийг хянаж, санхүүжилтийг олгох үе шатны хяналтыг холбогдох журмыг дагуу хэрэгжүүлсэн байна.

Зураг төсвийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг холбогдох материалыг үндэслэн шилжүүлжээ.

Аудитаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээг улсын комисс хүлээн авч, ашиглагч байгууллагад архивын холбогдох баримт материалын нэг хувийг олгохгүй байгаа нь Барилгын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалттай нийцэхгүй байна.

Иймд Барилгын тухай хуулийн 46.3-т заасан баримт бичгийг ашиглагч байгууллагад архив албан хэргийн стандартын шаардлага, бичиг баримтын бүрдлийг хангуулж, хүлээлгэн өгөхийг аймгийн Засаг дарга, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгөн оруулалтын хэлтэст зөвлөмж болголоо.

Б.3.Ашиглалтад хүлээн авсан зарим төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагууд бүртгэлд тусгаагүй байна

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжиж дууссан 42,362.2 сая төгрөгийн 12 төсөл арга хэмжээ, 2021, 2022 онд хэрэгжиж дууссан 3,279.4 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг ашиглагч байгууллагууд бүртгэлд тусгасан эсэхийг шалгаж үзэхэд 36,819.63 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээг орлого авч, нягтлан бодох бүртгэлд тусгасан байна./хавсралт №4/

Аудитаар 8,536.3 сая төгрөгийн өртөгтэй дараах төсөл арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байсан зөрчилд албан шаардлага өгөв.

- Өлгий сумын 4, 11 дүгээр багт Үерийн усны хамгаалалтын далан сувгийн эхний ээлжийн ажил, 5,542.6 сая төгрөг,
- Аймгийн төвийн хатуу хучилттай 3.1 км авто замын 2,908.3 сая төгрөг,
- Бугат сумын төвд баригдсан Халуун усны барилгын 85.4 сая төгрөгийн нэмэгдүүлсэн санхүүжилтийн дүнгээр зөрүүг орлогод аваагүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээг ашиглагч байгууллага нь нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, орлогод аваагүй орхигдуулсан нь төрийн өмч хөрөнгийг эзэнгүйдүүлэх сөрөг үр дагавартай юм.

1000, 900 айлын орон сууцны хороолол, ус дамжуулах төвийн гадна инженерийн шугам сүлжээний 3,229.8 сая төгрөгийн өртөгтэй төсөл арга хэмжээ нь Орон нутгийн өмчийн газрын дуусаагүй барилгад бүртгэлтэй байна.Энэхүү төсөл арга хэмжээг бүрэн хүчин чадлаар ашиглаж эхлээгүй бөгөөд тоногдох эрсдэлтэй байгаа тул харуул хамгаалалтын асуудлыг шийдэх нь зүйтэй байна.

В. Хэрэгжсэн төсөл, арга хэмжээний 93.0 хувь нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна

В.1. Хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн 92.9 хувь нь зориулалтын дагуу ашиглагдаж байна

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжиж буй 36 төсөл арга хэмжээний 14 төсөл арга хэмжээ нь 100 хувь дуусаж, ашиглалтад хүлээн авсан байна. Эдгээр төсөл арга хэмжээнүүдийг фото зургаар харуулбал:

- Засгийн газрын хэрэг эрхлэх газрын багцаар хэрэгжсэн Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилга /Баян-Өлгий, Өлгий сум/ -ыг 2023 оны 05 сарын 12-ны өдөр ашиглалтад хүлээн авсан ба 16 төрийн байгууллага үйл ажиллагаа явуулж, бүрэн хүчин чадлаар ажиллаж байна. Тус байр ашиглалтад орсноор 16 төсөвт байгууллага, 1 судалгааны хүрээлэн албаны контортой болсон ба сургалт семинар явуулах хурлын заал, төрийн албан хаагч нар байрлах 6 өрөө бүхий зочид буудалтай болсон байна. Түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байсан 8 төсөвт байгууллага нь стандартын шаардлага хангасан байртай болж, ард иргэдэд төрийн үйлчилгээг нэг дороос хүргэх боломж бүрдсэн үр өгөөжтэй хөрөнгө оруулалт болсон байна.



Эх сурвалж: Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилга

- Хүнс хөдөө ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын багцаар хэрэгжсэн Хүнс, хөдөө аж ахуйн газар, лабораторийн барилгад Хүнс хөдөө аж ахуйн газар үйл ажиллагаа явуулж, бүрэн хүчин чадлаар ашиглаж байна. Төрийн албан хаагчийн ажиллах ажлын байрны тав тухтай орчин бүрдэж, алсдаа лаборатори ажиллуулах өрөө тасалгааг урьдчилж бэлтгэсэн байна.



Эх сурвалж: Хүнс хөдөө аж ахуйн газар

- Боловсрол шинжлэх ухааны сайдын багцаар хэрэгжсэн Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум, 5 дугаар баг/, Цэцэрлэгийн барилга, 250 ор /Баян-Өлгий, Өлгий сум/, Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум, 4 дүгээр баг, 20 дугаар цэцэрлэг/ нь ашиглалтад орж, бүрэн хүчин чадлаар үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

Өлгий сумын 5 дугаар багт байрлалтай 12 дугаар цэцэрлэг нь хуучин гэр хороолол дотор стандартын бус байранд үйл ажиллагаа явуулж байсан бол 100 ортой цэцэрлэгийн барилга нь ашиглалтад орсноор стандартад нийцсэн тав тухтай орчин бүрдэж, шинэ байртай болсон.

4 дүгээр багт баригдсан 100 ортой цэцэрлэгийн барилгын талаар: Тус 20 дугаар цэцэрлэг нь аймгийн Ерөнхий боловсролын 9 дүгээр сургуулийн 1 давхард стандарт бус байранд үйл ажиллагаа явуулж байсан ба шинэ барилга ашиглалтад орсноор стандарт байранд хүүхдийн сурах, хүмүүжих тав тухтай орчин бүрдсэн байна.

Цэцэрлэг нь өмнө 3 бүлгээр үйл ажиллагаа явуулж байсан ба тус байр нь ашиглалтад орсноор шинээр 1 бүлэг нэмэгдсний дээр аймгийн төвийн алслагдсан захын 4 дүгээр багийн ард иргэдийн хүүхдүүд тав тухтай шинэ цэцэрлэгт хамрагдаж, сургалтын өмнөх боловсрол эзэмшүүлэх нөхцөл боломж бүрдсэн.

Өлгий сумын 1 дүгээр цэцэрлэг урьд нь 4 бүлэг, 100 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулж байсан. 250 ортой цэцэрлэг ашиглалтад орсноор 10 бүлгээр 382 хүүхдэд сургалтын өмнөх боловсрол олгох боломж бүрдэж, цэцэрлэгийн хүчин чадал 2 дахин нэмэгдэж, цэцэрлэгт хамрагдах хүүхдүүдийн тоо нэмэгдэж, ажлын байр нэмэгдсэн байна.



Эх сурвалж: 250 ортой хүүхдийн цэцэрлэг



Эх сурвалж: Өлгий сумын 5 дугаар багийн 100 ортой Хүүхдийн цэцэрлэг



Эх сурвалж: Өлгий сумын 4 дүгээр багийн 100 ортой Хүүхдийн цэцэрлэг

- Зам тээвэр харилцааны сайдын багцаар хэрэгжсэн Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Баян-Өлгий, Алтай сум/, Сумын төвийн хатуу хучилттай

авто зам, явган хүний зам, гэрэлтүүлэг, шугам сүлжээний хамгаалалт, өөрчлөлтийн ажил, 2.3 км /Баян-Өлгий, Толбо сум/, Уурхай, Сагсай сум чиглэлийн авто зам, гэрэлтүүлэг, шугам сүлжээ, 1.6 км /Баян-Өлгий, Өлгий, Сагсай сум/, Бетон гүүр /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөх хөтөл баг/, Тоорцог толгойн төмөр бетон гүүр /Баян-Өлгий, Бугат сум/, Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 3.1км зэрэг 6 төсөл арга хэмжээ нь зориулалтын дагуу ашиглагдаж байна.



Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Баян-Өлгий, Алтай сум/, Сумын төвийн хатуу хучилттай авто зам, явган хүний зам, гэрэлтүүлэг, шугам сүлжээний хамгаалалт, өөрчлөлтийн ажил, 2.3 км /Баян-Өлгий, Толбо сум/, Уурхай, Сагсай сум чиглэлийн авто зам, гэрэлтүүлэг, шугам сүлжээ, 1.6 км /Баян-Өлгий, Өлгий, Сагсай сум/, Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 3.1км зэрэг засмал зам ашиглалтад орсноор иргэдийн ая тухтай зорчих нөхцөл бүрдсэн.

Тоорцог толгойн төмөр бетон гүүр /Баян-Өлгий, Бугат сум/ ашиглалтад орсноор Бугат сумын Буга, Хатуу багийн малчид урьд аймгийн төвийг дайрч нүүдэг байсан бол одоо шинэ гүүрийг ашиглаж, нүүдэг болсны дээр Алтанцөгц сумын иргэд өвлийн улиралд нүүрсээ татах боломж бүрдсэн байна.



Эх сурвалж: Хэрэгжсэн төсөл арга хэмжээ

Барилга хот байгуулалтын сайдын багцаар хэрэгжсэн Халуун усны барилга /Баян-Өлгий, Бугат сум/ нь аймгаас төвөөс 5 км-ийн зайтай Бугат сумын төвд

баригдаж 2022 оны 10 дугаар сарын 26-нд ашиглалтад орсон боловч зориулалтын дагуу огт ашиглагдаагүй байна.



Эх сурвалж: Бугат сумын Халуун усны барилга

Сумын иргэд аймгийн төвд тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа, үйл ажиллагаа нь жигдэрсэн халуун усны төвөөр үйлчилгээ авахыг илүүд үздэг байна. Халуун усны барилгыг анхнаасаа буруу төлөвлөж барьсан, байршлаа олоогүй төсөл, арга хэмжээ болсон байна.

Аудитаар ашиглалтад орсон боловч бүрэн хүчин чадлаар ашиглаж эхлээгүй 2 төсөл арга хэмжээ байна. Үүнд:

- Үерийн усны хамгаалалтын далан сувгийн эхний ээлжийн ажил /Баян-Өлгий, Өлгий сум, 4, 11-р баг/ -уг төсөл арга хэмжээг ашиглалтад хүлээн авсан боловч бүрэн хүчин чадлаар ашиглаж эхлээгүй байна. Эрх шилжээгүй хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Үерийн усны хамгаалалтын далан суваг 12.3 км төсөл арга хэмжээ ашиглалтад орох хугацаа болоогүй байна. Үерийн усны хамгаалалтын далан суваг 12.3 км төсөл арга хэмжээ ашиглалтад орсноор үерийн усны хамгаалалтын далан нь бүрэн ашиглалтад орох юм.
- 1000, 900 айлын орон сууцны хороолол, ус дамжуулах төвийн гадна инженерийн шугам сүлжээний ажил /Баян-Өлгий, Өлгий/ нь ирээдүйд барих орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээний дэд бүтэц юм.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний 93.0 хувийг ашиглах зориулалтын дагуу бүрэн ашиглах боломжтой болсон нь эерэг үр дагавартай болсон байна гэж дүгнэлээ.

В.2. Хэрэгжсэн нэг төсөл арга хэмжээ төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж ашиглалтад орсон 14 төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагууд зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэх болон тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийн шалгаж үзэхэд:

Тайлант онд ашиглалтад орсон 13 төсөл арга хэмжээ тэргүүлэх ач холбогдол бүхий хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүн хүрсэн байна.

Бугат сумын 371.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй Халуун усны барилга нь 2022 онд ашиглалтад орсон боловч зориулалтын дагуу ашиглагдаагүй, төлөвлөсөн үр дүн хүрээгүй, үр өгөөжгүй хөрөнгө оруулалт болсон байна.

Аудитын дүнгээр 8,907.4 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага, 3 зөвлөмж өгөгдлөө.

ҮАГ-т уламжлах санал:

1.Цэнгэл сумын 320 суудалтай сургуулийн барилгын төсөвт өртгийг 12,367.0 сая төгрөгөөр тогтоосныг хянан үзэх шаардлагатай байна.

2. Баян-Өлгий аймагт эрх шилжсэн хөрөнгө оруулалтын санхүүжилт олгох, хянах эрхийг аймагт буцаан шилжүүлж өгөхийг санал болгож байна.

3. Өлгий сумын 10 дугаар багт 940 хүүхдийн сургууль, спорт заалны барилгын ажлыг гүйцэтгэгч “Турлиахт” ХХК барилга угсралтын ажлыг 8,601.1 сая төгрөгөөр 2023 оны 11 сарын 31-нд бүрэн дуусгаж хүлээлгэн өгөх ёстой байсан боловч зураг магадлалаар орж, төсөвт өртөг 13,834.3 сая төгрөг, хүлээлгэн өгөх хугацаа 2025 оны 12 дугаар арын 30-ны өдөр болж гэрээг шинэчлэн байгуулсан. Гүйцэтгэгчид 66.86 хувийн ажлын гүйцэтгэлээр 9,249.6 сая төгрөгийн санхүүжилт авсан. Компани өөрийн хөрөнгөөр ажлын гүйцэтгэлийг 85 хувьд хүргэсэн байна.Иймд компани зүгээс үлдсэн санхүүжилтийг 2024 онд шилжүүлэн өгөхийг хүсэж албан тоот ирүүлсэн байна.

4. Бага сургуулийн барилга, 160 суудал /Баян-Өлгий, Ногооннуур сум, 6 дугаар баг/ төсөл арга хэмжээний гүйцэтгэгч Мурап ХХК нь төсөл арга хэмжээг 2299.5 сая төгрөгийн өртгөөр хэрэгжүүлж, ашиглалтад оруулах боломжгүй байдалтай байгаа тул төсвийг эргэн хянан үзэх шаардлагатай байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-3762

Ард. М. Д. № 8-06/419
танай _____ -ны № _____ -т

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө
оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт,
үр дүнгийн тайланд өгөх саналын тухай

1. Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний баримт бичгийг ашиглагч байгууллагад архив албан хэргийн стандартын шаардлага, бичиг баримтын бүрдлийг хангуулан цахим хэлбэрээр хүлээлгэн өгөх саналтай байна. Зураг төсвийн байгууллагууд төсөл арга хэмжээний зураг төсвийн эх хувь 1, хуулбар 2 хувь үйлдэж хүлээлгэн өгдөг ба хүлээж авсан эх хувийг Худалдан авах ажиллагааны газарт тендер зарлуулахаар өгдөг тул захиалагч, ашиглагч, гүйцэтгэгчид зураг төсвийн эх хувь өгөх боломжгүй.

2. 2023 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүд Засгийн газрын 2021 оны 359 дүгээр тогтоолоор Засаг даргад эрх шилжин ирсэн тул төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилтийг аймгийн Засаг дарга бүрэн хангуулж ажиллах хэрэгтэй байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт,
хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга



Х.БАХЫТГҮЛ

0107240156

д/д	Холбогдох байгууллагын санал	Аудитын газраас өгсөн тайлбар
1	<p>Хэрэгжиж дуусан төсөл, арга хэмжээний баримт бичгийн ашиглагч байгууллагад архив албан хэргийн стандартын шаардлага, бичиг баримтын бүрдлийг хангуулан цахим хэлбэрээр хүлээлгэн өгөх саналтай байна. Зураг төсвийн байгууллагууд төсөл арга хэмжээний зураг төсвийн эх хувь 1, хуулбар хувь 2 хувь үйлдэж хүлээлгэн өгдөг ба хүлээж авсан эх хувийг Худалдан авах ажиллагааны газарт тендер залруулахаар өгдөг тул захиалагч, ашиглагч, гүйцэтгэгчид зураг төсвийн эх хувь өгөх боломжгүй.</p>	<p>Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 2 дугаар хавсралтад заасан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах техникийн комиссын дүгнэлт”-ийн 3.2.а-д “барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх” гэж заасан байна. Иймд ашиглагч, эзэмшигч байгууллагад барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн үлдэх хувийг цаасаар шилжүүлэн өгөх нь зүйтэй байгаа ул тайланд хэвээр үлдээв.</p>
2	<p>Засгийн газрын 2021 оны 359 дүгээр тогтоолоор 2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ нь эрх шилжиж ирсэн тул төсөл арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилтийг аймгийн Засаг дарга хангаж ажиллах шаардлагатай байна.</p>	<p>Улсын төсвийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний Баян-Өлгий аймагт эрх шилжсэн хөрөнгө оруулалтын санхүүжилт олгох, хянах эрхийг аймагт буцаан шилжүүлж өгөхийг санал болгож байна</p>

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Хөрөнгө оруулалтын санхүүжилтэд аймгаас олгосон санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.
2. Тайлант онд төлөвлөсөн арга хэмжээний 93.0 хувь нь хугацаанд хэрэгжсэн байна.
3. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд бүх шатны хяналтыг хэрэгжүүлсэн боловч зарим төсөл арга хэмжээний ажлууд дутуу байна.
4. Хэрэгжсэн төсөл арга хэмжээний 92.9 хувь нь иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангасан байна
5. Ашиглалтад оруулсан нэг төсөл арга хэмжээ зориулалтын дагуу ашиглагдаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

I. Аймгийн Засаг дарга А.Камелият, ОНӨГ-ын дарга Б.Серик -д:

1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлтийг хэрэгцээ шаардлага, бодит тооцоо судалгаанд үндэслэн хийх;
2. Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний баримт бичгийг ашиглагч байгууллагад архив албан хэргийн стандартын дагуу бичиг баримтын бүрдлийг хангуулж хүлээлгэн өгөх;
3. Хэрэгжсэн төсөл арга хэмжээтэй холбоотой гарсан зөрчил дутагдлыг арилган ажиллах,

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5-т заасан хугацаанд буюу зөвлөмжийг хүлээн авснаас 30 хоногийн дотор зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.АЙГҮЛ

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

М.АЙНУР

АУДИТОР

С.НУРЛАН

ХАВСРАЛТ:

Хавсралт №-1 Улсын комисс нь тайлант онд болон 2021-2022 онуудад байнгын ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний дүн	Улсын комиссын актын огноо	Ажлын гүйцэтгэл
А	1	2	4	5
Тайлант онд байнгын ашиглалтад хүлээн авсан ТАХ				
1	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум, 5 дугаар баг/	2249.53	2023.09.13	100%
2	Цэцэрлэгийн барилга, 250 ор /Баян-Өлгий, Өлгий сум/	3641.90	2023.12.04	100%
3	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум, 4 дүгээр баг, 20 дугаар цэцэрлэг/	2413.60	2023.12.01	100%
4	Үерийн усны хамгаалалтын далан сувгийн эхний ээлжийн ажил /Баян-Өлгий, Өлгий сум, 4, 11-р баг/	5542.60	2023.11.15	100%
5	Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Баян-Өлгий, Алтай сум/	2488.20	2023.11.02	100%
6	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, явган хүний зам, гэрэлтүүлэг, шугам сүлжээний хамгаалалт, өөрчлөлтийн ажил, 2.3 км /Баян-Өлгий, Толбо сум/	2971.10	2023.09.06	100%
7	Уурхай, Сагсай сум чиглэлийн авто зам, гэрэлтүүлэг, шугам сүлжээ, 1.6 км /Баян-Өлгий, Өлгий, Сагсай сум/	1826.90	2023.09.06	100%
8	Бетон гүүр /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөх хөтөл баг/	994.60	2023.11.01	100%
9	Тоорцог толгойн төмөр бетон гүүр /Баян-Өлгий, Бугат сум/	5789.90	2023.09.08	100%
10	Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилга /Баян-Өлгий, Өлгий сум/	9215.80	2023.05.12	100%
11	Хүнс, хөдөө аж ахуйн газар, лабораторийн барилга /Баян-Өлгий, Өлгий сум/	1998.30	2023.12.04	100%
12	1000, 900 айлын орон сууцны хороолол, ус дамжуулах төвийн гадна инженерийн шугам сүлжээний ажил /Баян-Өлгий, Өлгий/	3229.80		100%
	Дүн	42,362.23		
2021-2022 онд ашиглалтад хүлээн авсан ТАХ				
13	Халуун усны барилга /Баян-Өлгий, Бугат сум/	371.1	2022.10.26	100%
14	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 3.1км	2,908.3	2021.10.08	100%
	Дүн	3,279.4		
	НИЙТ ДҮН	45,641.63		

Эх сурвалж: Аудитын нэгдсэн судалгааны маягт

Хавсралт №2 Захиалагч, мэргэжлийн байгууллагын хяналт

№	Төсөл, арга хэмжээний нэр	ГХБХБГ	Барилга, захиалагчийн алба	Мэргэжлийн байгууллага
А	1	2	4	5
1	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум, 5 дугаар баг/	тийм		
2	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Баян-Өлгий, Сагсай сум, 5 дугаар баг/	тийм		
3	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Баян-Өлгий, Улаанхус сум/	тийм		
4	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Баян-Өлгий, Ногооннуур сум, Улаанбайшинт боомт/	тийм		
5	Цэцэрлэгийн барилга, 250 ор /Баян-Өлгий, Өлгий сум/	тийм		
6	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум, 4 дүгээр баг, 20 дугаар цэцэрлэг/	тийм		
7	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум/ 12 баг	тийм		
8	Цэцэрлэгийн барилга, 120 ор /Баян-Өлгий, Өлгий сум, Кутты мекен хотхон/	тийм		
9	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Баян-Өлгий, Баяннуур сум, "Ак арал" баг/	тийм		
10	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Баян-Өлгий, Булган сум, Сайхан баг/	тийм		
11	Бага сургуулийн барилга, 160 суудал /Баян-Өлгий, Ногооннуур сум, 6 дугаар баг/	тийм		
12	Дотуур байрны барилга, 100 ор /Баян-Өлгий, Алтанцөгц сум/	тийм		
13	Сургуулийн барилга, 320 суудал /Баян-Өлгий, Цэнгэл сум/	тийм		
14	Сургуулийн дотуур байрны барилга, 30 ор /Баян-Өлгий, Ногооннуур сум, 2 дугаар баг/	тийм		
15	Сургуулийн спорт заалны барилга /Баян-Өлгий, Булган сум, 4 дүгээр баг/	тийм		
16	Сургуулийн барилга, спорт заал, 940 суудал /Баян-Өлгий, Өлгий/	тийм		
17	Сургуулийн спорт заалны барилга /Баян-Өлгий, Баяннуур сум, 1, 3, 5 дугаар баг, Багц-1/	тийм		
18	Сургуулийн спорт заалны барилга /Баян-Өлгий, Баяннуур сум, 1, 3, 5 дугаар баг, Багц-2/	тийм		
19	Сургуулийн спорт заалны барилга /Баян-Өлгий, Баяннуур сум, 1, 3, 5 дугаар баг, Багц-3/	тийм		
20	Үерийн усны хамгаалалтын далан сувгийн эхний ээлжийн ажил /Баян-Өлгий, Өлгий сум, 4, 11-р баг/	тийм		
21	1000, 900 айлын орон сууцны хороолол, ус дамжуулах төвийн гадна инженерийн шугам сүлжээний ажил /Баян-Өлгий, Өлгий/	тийм		
22	Халуун усны барилга /Баян-Өлгий, Бугат сум/	тийм		
23	Соёлын төвийн барилга, 300 суудал /Баян-Өлгий, Толбо сум/	тийм		
24	Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилга /Баян-Өлгий, Өлгий сум/	тийм		
25	Эрүүл мэндийн төвийн барилга, 20 ор /Баян-Өлгий, Өлгий сум, Хотгор баг/	тийм		
26	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, явган хүний зам, гэрэлтүүлэг, шугам сүлжээний хамгаалалт, өөрчлөлтийн ажил, 2.3 км /Баян-Өлгий, Толбо сум/		тийм	
27	Уурхай, Сагсай сум чиглэлийн авто зам, гэрэлтүүлэг, шугам сүлжээ, 1.6 км /Баян-Өлгий, Өлгий, Сагсай сум/		тийм	
28	Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Баян-Өлгий, Алтанцөгц/		тийм	тийм
29	Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Баян-Өлгий, Алтай сум/		тийм	тийм
30	Бетон гүүр /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөх хөтөл баг/		тийм	тийм
31	Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга /Баян-Өлгий, Өлгий/		тийм	тийм
32	Алтай Таван Богдын байгалийн цогцолборт газрын цахилгаан хангамж /Баян-Өлгий, Цэнгэл сум/		тийм	тийм
33	Хилийн цэргийн 0165 дугаар ангийн 1, 2 дугаар заставын цахилгаан хангамж /Баян-Өлгий, Цэнгэл сум/		тийм	тийм
ДҮН		25	8	6

Эх сурвалж: Аудитын нэгдсэн судалгааны маягт

Хавсралт: №3 Зураг төсөл зохиогчийн хяналт

№	Зураг төсөл зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн хуулийн этгээдийн нэр	Төсөл, арга хэмжээний тоо
A	1	2
1	"АЕСН" ХХК,	10.00
2	"Эм Си Пи Си Жи Ар" ХХК	3.00
3	"Кадсүрвэй" ХХК	3.00
4	"Жаргалант хийц" ХХК	2.00
5	"Бодит чадал" ХХК	2.00
6	"Максимумлайн" ХХК	2.00
7	"Зэдпрожект" ХХК	2.00
8	"Скайлайн дизайн" ХХК	1.00
9	"Рус-Нур" ХХК	1.00
10	"Кингсий инженер энд констракшн консалтинг групп" ХХК	1.00
11	"ТГТ" ХХК	1.00
12	"Тод прогресс" ХХК	1.00
13	"Аркон" ХХК	1.00
14	"Монхидроконстракшн"ХХК	1.00
15	"ДНТ" ХХК	1.00
16	"Ихэр Мөнх" ХХК	1.00
17	"Энх энэрлийн өргөө" ХХК	1.00
18	"Бююдилгс технологи" ХХК	1.00
19	"Криетив Монголия" ХХК	1.00
НИЙТ ДҮН		36.00

Эх сурвалж: Аудитын нэгдсэн судалгааны маягт

Хавсралт:№4 Төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авч, нягтлан бодох бүртгэлд тусгасан төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Төсөл, арга хэмжээний нэр	Байнгын ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээ		Ажлын гүйцэтгэл
		Бүртгэлд авсан дүн	Улсын комиссын актын огноо	
A	1	2	4	5
1	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум, 5 дугаар баг/	2249.53	2023.09.13	100%
2	Цэцэрлэгийн барилга, 250 ор /Баян-Өлгий, Өлгий сум/	3641.90	2023.12.04	100%
3	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум, 4 дүгээр баг, 20 дугаар цэцэрлэг/	2413.60	2023.12.01	100%
4	Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Баян-Өлгий, Алтай сум/	2488.20	2023.11.02	100%
5	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, явган хүний зам, гэрэлтүүлэг, шугам сүлжээний хамгаалалт, өөрчлөлтийн ажил, 2.3 км /Баян-Өлгий, Толбо сум/	2971.10	2023.09.06	100%
6	Уурхай, Сагсай сум чиглэлийн авто зам, гэрэлтүүлэг, шугам сүлжээ, 1.6 км /Баян-Өлгий, Өлгий, Сагсай сум/	1826.90	2023.09.06	100%
7	Бетон гүүр /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөх хөтөл баг/	994.60	2023.11.01	100%
8	Тоорцог толгойн төмөр бетон гүүр /Баян-Өлгий, Бугат сум/	5789.90	2023.09.08	100%
9	Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилга /Баян-Өлгий, Өлгий сум/	9215.80	2023.05.12	100%
10	Хүнс, хөдөө аж ахуйн газар, лабораторийн барилга /Баян-Өлгий, Өлгий сум/	1998.30	2023.12.04	100%
11	1000, 900 айлын орон сууцны хороолол, ус дамжуулах төвийн гадна инженерийн шугам сүлжээний ажил /Баян-Өлгий, Өлгий/	3,229.8	2023.12.22	100%
НИЙТ ДҮН		36,819.63		

Эх сурвалж: Аудитын нэгдсэн судалгааны маягт



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/09

Өлгий

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Эрх шилжүүлэх тухай” А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1-ийн 1.1, 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг 1 дүгээр хавсралтаар, төлбөрийн акт, албан шаардлагыг 2 дугаар хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг аймгийн Засаг дарга (А.Камелият)-д зөвлөсүгэй.
4. Аудитын дүнгээр өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор (М.Айнур)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Женисбек)-т тус тус даалгасугай.



Ж.АЙГҮЛ

00401031